



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпорац ХХК" ТБОНӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2024/05/НА-СТА-ОНА**

Цахим хуудас:

[www.Umnugovi@audit.mn](http://www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг

Даланзадгад сум

2024 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудитор: Э.Жаргал

Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Аудитын код: **ӨМА-2024/05/НА-СТА-ОНА**

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.09.15 № 258  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ӨМНӨГОВЬ ГУРВАНСАЙХАН ОРОН  
СУУЦНЫ КОРПОРАЦ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ А.НАРАНЦЭЦЭГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпорац ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпорац ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгө дутагдуулсан, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 6,694.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан "Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбоход дэмжлэг үзүүлэх тухай журам"-ын дагуу 577,626.4 мянган төгрөгөөр 86 өрхийг цэвэр усны шугамд, 98 өрхийг бохир усны шугамд холбох ажлыг зохион байгуулсан байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд 8,193,504.7 мянган төгрөгийн 59 айлын 2,806.1 м2 байрыг бүртгэлд тусгаж түрээсийн гэрээ байгуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

016020469

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 80 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>484,657,450.27</u></b>	<b><u>950,426,871.81</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>414,914,458.16</b>	<b>834,369,113.26</b>
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>414,914,458.16</b>	<b>834,369,113.26</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	414,914,458.16	834,369,113.26
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>51,525,287.11</b>	<b>35,993,093.55</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,492,537.36	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	8,941,383.93	734,760.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	6,050,000.00	6,050,000.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	2,258,864.45	625,832.18
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>22,782,501.37</b>	<b>28,582,501.37</b>
3351	Байгууллагаас авах авлага	7,672,501.37	7,672,501.37
3352	Хувь хүмүүсээс авах авлага	15,110,000.00	20,910,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>18,217,705.00</b>	<b>80,064,665.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>4,136,825.00</b>	<b>64,076,825.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	4,136,825.00	64,076,825.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>14,080,880.00</b>	<b>15,987,840.00</b>
35410	Бичиг хэргийн материал	5,423,200.00	6,430,650.00
35440	Түлш, шатах тослох материал	-	490,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,657,680.00	9,067,190.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>14,072,186,027.25</u></b>	<b><u>22,023,794,032.41</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>14,072,186,027.25</b>	<b>22,023,794,032.41</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>14,071,769,360.45</b>	<b>22,022,144,032.41</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,491,527,581.75	22,761,708,015.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(471,751,343.13)	(787,453,569.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,605,700.00	39,970,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,632,422.52)	(19,279,549.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,888,652.00	33,626,552.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,868,807.65)	(6,427,715.92)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>416,666.80</b>	<b>1,650,000.00</b>
39301	Программ хангамж	2,500,000.00	4,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,083,333.20)	(2,500,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>14,556,843,477.52</u></b>	<b><u>22,974,220,904.22</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>14,264,702,996.55</u></b>	<b><u>22,412,308,084.61</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>244,926,802.36</b>	<b>438,053,682.95</b>
<b>413</b>	<b>ӨГЛӨГ</b>	<b>4,463,605.57</b>	<b>64,099,725.00</b>
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	4,136,825.00	64,076,825.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>326,780.57</b>	<b>22,900.00</b>
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	302,048.57	-
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	24,732.00	22,900.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>240,463,196.79</b>	<b>373,953,957.95</b>
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	29,091,411.00	32,617,323.16
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	211,371,785.79	252,531,560.79
41440	Бусад урьдчилж орсон орлого /өмчлөл/	-	88,805,074.00
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,019,776,194.19</b>	<b>21,974,254,401.66</b>
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>14,019,776,194.19</b>	<b>21,974,254,401.66</b>
<b>4221</b>	<b>Төгрөг</b>	<b>14,019,776,194.19</b>	<b>21,974,254,401.66</b>
42217	Санхүүгийн бусад байгууллага	14,019,776,194.19	21,974,254,401.66

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>292,140,480.97</b>	<b>561,912,819.61</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>292,140,480.97</b>	<b>561,912,819.61</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /орон нутгийн сан/	8,000.00	8,000.00
51101	Өмч: - төрийн	8,000.00	8,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>292,132,480.97</b>	<b>561,904,819.61</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	95,006,741.67	292,132,480.97
51220	Тайлант үеийн үр дүн	197,125,739.30	269,772,338.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>14,556,843,477.52</b>	<b>22,974,220,904.22</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	358,333,120.00	1,036,292,356.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	253,711,071.68	895,308,628.91
3	Нийт ашиг (алдагдал)	104,622,048.32	140,983,727.09
5	Хүүгийн орлого	14,186,082.19	27,935,218.70
9	Борлуулалт, маркетингийн зардал	253,711,071.68	315,702,225.91
5	Ерөнхий ба удирдлагын зардал	150,890,602.97	185,082,462.09
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,600,000.00	-
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	219,028,599.22	299,538,709.61
10	Орлогын татварын зардал	21,902,859.92	29,953,870.96
11	Татварын дараах ашиг (алдагдал)	197,125,739.30	269,584,838.65
13	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	197,125,739.30	269,584,838.65

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,000.00	292,132,480.97	292,140,480.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
Тайлант үеийн үр дүн			-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,000.00	292,132,480.97	292,140,480.97
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,000.00	292,132,480.97	292,140,480.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,000.00	292,132,480.97	292,140,480.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-
Тайлант үеийн үр дүн		269,772,338.64	269,772,338.64
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>8,000.00</b>	<b>561,904,819.61</b>	<b>561,912,819.61</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>748,469,042.73</b>	<b>1,229,325,488.15</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	748,469,042.73	1,229,325,488.15
120	Нийтлэг татварын бус орлого	17,380,602.73	27,596,576.70

120002	Хүүгийн орлого	17,380,602.73	27,596,576.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	731,088,440.00	1,201,728,911.45
120009	Бусад орлого	66,000,531.00	48,047,310.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	665,087,909.00	1,153,681,601.45
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>531,660,807.18</b>	<b>800,118,333.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>531,660,807.18</b>	<b>800,118,333.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>531,660,807.18</b>	<b>800,118,333.05</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,597,385.00	101,920,100.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	135,597,385.00	101,920,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,251,914.02	33,691,942.36
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	20,251,914.02	33,691,942.36
2104	Хангамж, бараа материалын зардал	318,859,165.54	38,231,071.10
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	318,859,165.54	38,231,071.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,952,342.62	626,275,219.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад, ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	587,202,421.00
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	3,194,520.54	-
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	31,027,685.93	39,072,798.59
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	22,730,136.15	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	216,808,235.55	429,207,155.10
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,657,722.00	9,752,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,657,722.00	9,752,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,657,722.00	9,752,500.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	16,657,722.00	9,752,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(16,657,722.00)	(9,752,500.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	200,150,513.55	419,454,655.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	214,763,944.61	414,914,458.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	414,914,458.16	834,369,113.26

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 он			
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого (цэвэр)	358,333,120.0	1,030,297,515.0	1,036,292,356.00	-5,994,841	100.5819
2	Борлуулалтын өртөг	253,711,071.7	645,590,533.0	895,308,628.91	-249,718,096	138.6806
3	Нийт ашиг (алдагдал)	104,622,048.3	384,706,982.0	140,983,727.09	243,723,255	36.64704
4	Үйл ажиллагааны зардал	150,890,603.0	280,443,035.0	184,874,128.77	95,568,906	65.92217
5	Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	-150,890,603.0	-280,443,035.0	-184,874,128.77	-95,568,906	65.92217
6	Туслах үйл ажиллагааны орлого	267,897,153.9	329,888,307.0	343,637,444.61	-13,749,138	104.1678
7	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2,600,000.0	0.0	0.00	0	
8	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал	265,297,153.9	329,888,307.0	343,637,444.61	-13,749,138	104.1678
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	219,028,599.2	434,152,254.0	299,747,042.93	134,405,211	69.04192
10	Орлогын татварын зардал	21,902,859.9	43,415,225.4	29,974,704.29	13,440,521	69.04192
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	197,125,739.3	390,737,028.6	269,772,338.64	120,964,690	69.04192

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 208.3 мянган төгрөгийн НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа илэрснээс аудитын явцад залруулсан байна.

*Залруулсан алдаа:*

1. Биет бус хөрөнгийн элэгдлийг 208.3 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн,

#### 3.1 Төлбөрийн акт

**Илрүүлэлт: 1** Үндсэн хөрөнгийн хяналтын тооллого хийхэд 5,800.0 мянган төгрөгийн 1 ширхэг компьютер биетээр байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4 "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 11 сарын 25-ны өдрийн А/89 дугаар тушаалаар баталсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралтын 11.1.5-д заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоох

**Илрүүлэлт: 2** Тус байгууллага нь төсвийн хөрөнгөөр 94.5 мянган төгрөгөөр пиво, сөжү худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.7 "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-д заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 11 сарын 25-ны өдрийн А/89 дугаар тушаалаар баталсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралтын 11.1.7-д заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоох

**Илрүүлэлт: 3** албан хаагчдын хүүхдүүдэд шинэ жилийн баярт зориулан 800.0 мянган төгрөгийн бэлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 11 сарын 25-ны өдрийн А/89 дугаар тушаалаар баталсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралтын 11.1.5-д заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоох

### 3.2 Албан шаардлага

**Илрүүлэлт: 1** Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 гүйлгээ буюу 211,845.3 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрээр мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт: 2** Шилэн дансны нэгдсэн системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, дараа жилийн зорилтот түвшин, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1 "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.3 "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор" , 6.10 "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. Албан шаардлага хүргүүлэх

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тус байгууллага нь хадгаламжийн дансанд 380,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь АИТХ-ын 2022 оны 5/20 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд заасны дагуу хөрөнгийг зарцуулан ажиллах

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад төсөв хэмнэгдсэн болон төсөв хэмнэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

**Илрүүлэлт: 2** Тайлант хугацаанд тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөө бүхий бараа,

үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган цахим дэлгүүрээс худалдан авалт хийж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн хяналтын тооллого хийхэд 5,800.0 мянган төгрөгийн 1 ширхэг компьютер биетээр байхгүй	1	5,800.0	1	5,800.0								
Тус байгууллага нь хадгаламжийн дансанд 380,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.	1	-		-			1	-				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>5,800.0</b>	<b>1</b>	<b>5,800.0</b>	-	-	<b>1</b>	-	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитын код: ӨМА-2024/05/НА-СТА-ОНА

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 гүйлгээ буюу 211,845.3 мянган төгрөгийг мэдээлээгүй	1	211,845.3			1	211,845.33		
нэгдсэн системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, дараа жилийн зорилтот түвшин, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн мэдээллийг тус тус байршуулаагүй	1	-				-		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>211,845.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>211,845.33</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тус байгууллага нь төсвийн хөрөнгөөр 94.5 мянган төгрөгөөр пиво, сөжү худалдан авсан	1	94.5	1	94.5				
албан хаагчдын хүүхдүүдэд шинэ жилийн баярт зориулан 800.0 мянган төгрөгийн бэлэг олгосон	1	800.0		800.0				
Тайлант хугацаанд тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>894.5</b>	<b>1</b>	<b>894.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>212,739.8</b>	<b>1</b>	<b>894.5</b>	<b>1</b>	<b>211,845.3</b>	<b>1</b>	<b>-</b>

